



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/355

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мэргэжлийн хяналтын ажилтны өдрийг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа амжилт гарган хамт олноо манлайлан ажиллаж буй Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч И.Алтанчимэг, Ш.Должинсүрэн, лабораторийн нян судлалын шинжээч М.Батбилэг нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 90000 төгрөг /Ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02.01782  
D/Zax-A/355-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны  
06 дугаар сарын 06-ны өдрийн  
А/355 дугаар захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН "ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ"-ӨӨР  
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Арга хэмжээ	Олгох шагнал
1	И.Алтанчимэг	Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч	Мэргэжлийн хяналтын ажилтны өдөр	30000
2	Ш.Должинсүрэн	Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч	Мэргэжлийн хяналтын ажилтны өдөр	30000
3	М.Батбилэг	Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн нян судлалын шинжээч	Мэргэжлийн хяналтын ажилтны өдөр	30000
Дүн				90000